


АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



**“ХҮН БОЛОХ БАГААСАА” ХҮҮХДИЙН СПОРТЫН СУРГАЛТЫН ТӨСЛИЙН
ТЕЛЕ БОЛОН ЦАХИМ ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

Ерөнхий мэдээлэл:

“Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төсөл нь Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/17 дугаар тогтоолоор батлагдсан.

“Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төслийн зорилго нь Дорнод аймгийн хүүхэд багачуудын спортын чадварыг нээн хөгжүүлэх, эрүүл чийрэг бие бялдартай, багаар ажиллах чадвартай, зөв хүмүүжилтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх.

Хамрах хүрээ, хугацаа: Аймгийн төв болон хөдөөгийн 13 сумын нийт хүүхэд, багачууд, гэр бүлд.

Санхүүжилт:

“Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төслийн зардлаас 15,0 сая төгрөг /орон нутгийн хөгжлийн сан/

Теле болон цахим сургалт явуулах ерөнхий шаардлага:

1.	“Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төслийн теле болон цахим хичээл сургалтын нэр төрөл: 1. Шатар 2. 100 буудалт даам 3. Үндэсний бөх 4. Үндэсний сур 5. Үндэсний шагай харваа 6. Хөнгөн атлетик 7. Жүдо 8. Бокс 9. Чөлөөт бөх 10. Таеквондо 11. Жиу Жицу 12. Ширээний теннис 13. Бадминтон 14. Хөлбөмбөг 15. Волейбол 16. Сагсан бөмбөг 17. Хувь хүний хөгжлийн сургалт <i>/Төндэрт оролцогч нь “Хүн болох багаасаа” хүүхдийн спортын сургалтын төслийн теле болон цахим хичээл сургалтыг дээрх төрлүүдээр зохион байгуулна/</i>
2.	Теле болон цахим сургалтыг “Хүн болох багаасаа” төслийн спортын дугуйлан, секц, клуб хичээллүүлж байгаа талуудтай хамтран зохион байгуулах.
3.	Теле болон цахим сургалтыг олон нийтэд хэвлэл, мэдээлэл, facebook page болон цахим хуудсаар зохион байгуулж, түгээн дэлгэрүүлсэн байх.
4.	Теле болон цахим хичээл, контент, төслийн мэдээ мэдээлэлд Дорнод аймгийн лого, төслийн нэр, таних тэмдгийг байршуулсан байх.
5.	Зохиогчийн оюуны өмчийн эрх нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу байх

6.	Теле болон цахим сургалт, мэдээллийг DVD болон эх файлаар захиалагч талд хүлээлгэн өгөх
----	---

Тендэрт оролцогчдод тавигдах шаардлага:

1.	Тендэрт оролцох албан хүсэлт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2.	Байгууллагын танилцуулга: Үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга
3.	Ажлын туршлага: Теле болон цахим сургалт зохион байгуулж байсан туршлага, амжилтын түүх, хамтран ажилласан байгууллагын мэдээлэл
4.	Хүний нөөцийн мэдээлэл: Мэргэжлийн боловсон хүчний танилцуулга /сэтгүүлч, зураглаач, техникийн ажилтан зэрэг/
5.	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хүчин чадал: Теле болон цахим сургалтыг дамжуулах ТВ суваг, цахим хуудас, facebook page, дүрс, бичлэгийн студи, тоног төхөөрөмж
6.	Төсвийн дэлгэрэнгүй: Теле болон цахим сургалт зохион байгуулах нийт төсвийн дэлгэрэнгүй задаргаа.

ХЯНАСАН
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ЭРДЭНЭБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЧИМЭЛДОРЖ

